

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн харьяатын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/9/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 51-261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор: О.Баярмаа Утас:51-261628 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn Аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/818
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн харьяатын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн харьяатын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гадаадын иргэний оршин суух үнэмлэх хэвлэх ажиллагааг хувийн хэвшлийн байгууллага гүйцэтгэж ирснийг 2023 оны 04 дүгээр сараас эхлэн зогсоож, байгууллага өөрөө бие даан хэвлэж эхэлснээр 34,000 орчим оршин суух үнэмлэх хэвлэн улсын төсөвт 908.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн цахимаар олгох визийн төрлийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулсны үр дүнд орон нутгийн төсөвт 4,985.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлж, төсвийн орлого бүрдүүлэлтэд тодорхой хувь нэмэр оруулаад байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын 2,389.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бүхий конторын барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн ББКД-84-33/23 дугаартай улсын комиссын дүгнэлт гарсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төсөвт тус барилга байгууламжийн гадна шугам сүлжээ, тохижилтын ажилд 423.7 сая төгрөгийн төсвийг нэмж төлөвлөсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Гадаадын иргэн харьяатын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98.4 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,498,323.1	4,307,986.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,790.6	68,834.8
34	УРЬДЧИЛГАА	25,951.8	29,410.8
35	БАРАА МАТЕРИАЛ	1,991,580.9	1,819,952.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,449,999.8	2,389,788.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,423,849.0	9,554,154.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,423,849.0	9,554,154.1
39200	Биет хөрөнгө	7,403,484.1	8,061,889.6
39300	Биет бус хөрөнгө	1,020,364.9	1,492,264.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,922,172.1	13,862,140.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,910.0	23,861.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,910.0	23,861.2
41300	Өглөг	6,549.0	3,820.0
41400	Урьдчилж орсон орлого	8,361.0	20,041.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,907,262.2	13,838,279.1
51	Засгийн газрын хувь оролцоо	11,907,262.2	13,838,279.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,433,292.5	1,433,292.5
51200	Хуримтлагдсан үр дүн	8,168,045.2	10,193,127.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,305,924.5	2,211,859.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,922,172.1	13,862,140.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,943,093.3	15,620,041.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,399,865.6	4,568,887.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,399,865.6	4,568,887.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,543,227.7	11,051,153.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,073,680.4	12,936,673.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,073,680.4	12,936,673.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,871,949.8	10,335,681.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,689,951.1	6,171,858.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	577,322.4	758,398.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	347,802.2	333,573.2
2104	Хангамж, бараа материалын зардал	389,053.2	521,746.8
2105	Нормативт зардал	807.7	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	253,846.8	125,125.8
2107	Томилолт, зочны зардал	13,323.9	82,293.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	381,973.2	1,098,157.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,217,869.3	1,244,527.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,201,730.6	2,600,991.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,869,412.9	2,683,367.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,721.4	752,350.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,861,691.5	1,931,016.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	11,643,973.9	17,015,172.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,906,988.9	5,010,858.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,906,988.9	5,010,858.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,906,988.9	5,010,858.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,757.3	953,161.1
120	Нийтлэг татварын бус орлого	193,757.3	953,161.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,543,227.7	11,051,153.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,857,412.3	15,871,838.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,857,412.3	15,871,838.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,751,866.0	8,285,689.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,689,951.1	6,171,759.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	577,322.4	758,023.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	354,590.0	330,788.6
2104	Хангамж, бараа материалын зардал	266,328.1	213,322.7
2105	Нормативт зардал	92,544.0	49,810.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	273,431.2	155,963.2
2107	Томилолт, зочны зардал	13,323.9	82,293.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	341,359.4	414,973.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,015.9	108,756.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,105,546.4	7,586,149.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,786,561.6	1,143,334.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,789,207.1	1,093,866.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,789,207.1	1,093,866.1
2200	Дотоод эх үүсвэрээр	1,789,207.1	1,093,866.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,789,207.1)	(1,093,866.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(741.7)	(11,423.8)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	741.7	11,423.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,387.2)	38,044.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,177.7	30,790.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,790.6	68,834.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,045,570.7	10,045,570.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	38,647.2	38,647.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,084,217.9	10,084,217.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(38,647.2)	(38,647.2)
9	Тайлант үеийн үр дүн	1,861,691.5	1,861,691.5
11	2022 оны 21-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,907,262.2	11,907,262.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	94,065.1	94,065.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,001,327.3	12,001,327.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(94,065.1)	(94,065.1)
19	Тайлант үеийн үр дүн	1,931,016.9	1,931,016.9
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	13,838,279.1	13,838,279.1

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,554,483,100.00	9,778,151,314.46	776,331,785.54	92.6
УРСГАЛ ЗАРДАЛ	9,614,683,100.00	8,838,362,736.46	776,320,363.54	91.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,093,538,100.00	8,338,341,180.39	755,196,919.61	91.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,625,975,000.00	6,171,758,999.26	454,216,000.74	93.1
Үндсэн цалин	3,700,709,400.00	3,642,840,695.97	57,868,704.03	98.4
Нэмэгдэл	1,508,308,400.00	1,197,577,120.30	310,731,279.70	79.4
Унаа хоолны хөнгөлөлт	940,785,100.00	894,555,452.17	46,229,647.83	95.1
Урамшуулал	476,172,100.00	436,785,730.82	39,386,369.18	91.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	909,754,300.00	758,023,305.42	151,730,994.58	83.3
Тэтгэврийн даатгал	618,612,000.00	517,843,693.46	100,768,306.54	83.7
Тэтгэмжийн даатгал	72,784,200.00	61,469,720.71	11,314,479.29	84.5
ҮОМШӨ-ний даатгал	58,228,700.00	48,626,413.10	9,602,286.90	83.5
Ажилгүйдлийн даатгал	14,557,800.00	11,817,629.15	2,740,170.85	81.2
Эрүүл мэндийн даатгал	145,571,600.00	118,265,849.00	27,305,751.00	81.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,962,400.00	330,788,570.14	45,173,829.86	88.0
Гэрэл, цахилгаан	102,263,800.00	83,575,578.50	18,688,221.50	81.7
Түлш, халаалт	82,003,500.00	72,942,774.25	9,060,725.75	89.0
Цэвэр, бохир ус	19,128,200.00	15,307,119.27	3,821,080.73	80.0
Байрны түрээс	172,566,900.00	158,963,098.12	13,603,801.88	92.1
Хангамж, бараа материалын зардал	223,115,400.00	213,322,734.27	9,792,665.73	95.6
Бичиг хэрэг	31,496,800.00	31,465,237.00	31,563.00	99.9
Тээвэр, шатахуун	90,836,500.00	90,309,835.00	526,665.00	99.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,242,400.00	41,692,371.27	3,550,028.73	92.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,285,000.00	5,115,000.00	170,000.00	96.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,254,700.00	44,740,291.00	5,514,409.00	89.0
Нормативт зардал	49,873,500.00	49,810,000.00	63,500.00	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,000.00	35,000.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,838,500.00	49,775,000.00	63,500.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	283,661,900.00	269,239,660.00	14,422,240.00	94.9
Багаж, техник, хэрэгсэл	136,386,200.00	135,982,780.00	403,420.00	99.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,160,500.00	5,550,000.00	610,500.00	90.1
Урсгал засвар	141,115,200.00	127,706,880.00	13,408,320.00	90.5
Томилолт, зочны зардал	53,769,100.00	38,468,460.80	15,300,639.20	71.5
Гадаад албан томилолт	12,560,000.00	9,622,996.80	2,937,003.20	76.6
Дотоод албан томилолт	31,609,100.00	23,785,200.00	7,823,900.00	75.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	9,600,000.00	5,060,264.00	4,539,736.00	52.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,360,400.00	405,173,298.50	54,187,101.50	88.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	152,298,800.00	140,673,688.00	11,625,112.00	92.4
Даатгалын үйлчилгээ	93,443,600.00	73,115,674.24	20,327,925.76	78.2
Тээврийн хэрэгслийн татвар	2,894,300.00	2,676,717.00	217,583.00	92.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	940,100.00	806,000.00	134,100.00	85.7

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	94,097,600.00	73,989,711.26	20,107,888.74	78.6
Газрын төлбөр	4,216,400.00	4,118,258.00	98,142.00	97.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	110,781,700.00	109,793,250.00	988,450.00	99.1
Бараа үйлчилгээний бусад зардал	112,066,100.00	101,756,152.00	10,309,948.00	90.8
Бараа үйлчилгээний бусад зардал	61,135,200.00	53,044,587.00	8,090,613.00	86.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,930,900.00	48,711,565.00	2,219,335.00	95.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	521,145,000.00	500,021,556.07	21,123,443.93	95.9
Бусад урсгал шилжүүлэг	521,145,000.00	500,021,556.07	21,123,443.93	95.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,942,200.00	17,390,000.00	1,552,200.00	91.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	900,000.00	-	900,000.00	-
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	488,069,100.00	470,921,556.07	17,147,543.93	96.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,233,700.00	11,710,000.00	1,523,700.00	88.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	939,800,000.00	939,788,578.00	11,422.00	100.0
Барилга байгууламж	939,800,000.00	939,788,578.00	11,422.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,554,483,100.00	9,778,151,314.46	776,331,785.54	92.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,544,483,100.00	8,869,990,209.86	1,674,492,890.14	84.1
Улсын төсвөөс санхүүжих	10,544,483,100.00	8,869,990,209.86	1,674,492,890.14	84.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	908,161,104.60	(898,161,104.60)	9,081.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	908,161,104.60	(898,161,104.60)	9,081.6
БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8	-	
Төсвийн байгууллага	8	8	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	310	273	37	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	221	192	29	
Үйлчлэх ажилтан	88	80	8	

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	520,605,174.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	520,605,174.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	92,624,804.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	22,000,000.00
Багаж, техник, хэрэгсэл	-	6,000,000.00
Урсгал засвар	-	16,000,000.00
Томилолт, зочны зардал	-	43,824,804.00
Гадаад албан томилолт	-	43,824,804.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	19,800,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	19,800,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	427,980,370.00
Бусад урсгал шилжүүлэг	-	342,450,860.46
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	309,340,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	33,110,860.46
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	85,529,509.54
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	85,529,509.54
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	520,605,174.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	520,605,174.00
ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	62,110,861.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,494,313.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	350,000,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 5 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 6,316.9 сая төгрөгийн 32 алдаа, зөрчил илэрснээс 6,169.9 сая төгрөгийн 9 алдаа¹ залруулж, 3.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 32.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэн, 111.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 17 зөвлөмжийг өгсөн.

Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6,272.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 6,158.3 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 3.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 111.3 сая төгрөгийн 13 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 587.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Нэмэлт санхүүжилтийн 350.0 сая төгрөгийн орлогыг тайлагнаагүй;
- Үнэт цаасны эд хариуцагчийг өөрчлөхдөө улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлыг 725.4 сая төгрөгөөр бууруулах бичилт хийсэн, цэцэрлэгээр төлүүлсэн 2.6 сая төгрөгийн тогтмол зардлыг авлагын дансаар дамжуулалгүй, гэрэл цахилгаан, халаалтын зардлыг бууруулах бичилт хийсэн;
- Цалингийн зардлыг 45.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Тэмдэгтийн хураамжийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийг 4,447.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитаар залрууллаа.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Гадаадын иргэн, харьяатын газрын мөнгөн хөрөнгийн дансанд 2015 онд байршуулсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эзэн холбогдогч нь тодорхойгүй барьцаа хөрөнгийн 2.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 2,3. Гадаадын иргэн, харьяатын газар тайлант онд нэр бүхий 2 ажилтанд 0.3 сая төгрөгийн, ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар тайлант онд нэр бүхий 4 ажилтанд нийт 0.7 сая төгрөгийн цалинг тус тус илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 201 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдад илүү олгосон 1.0 сая төгрөгийн цалинг тооцооллын алдаа гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Гадаадын иргэн, харьяатын газарт:

1. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Татварын цахим системийн тодорхойлолтоор 3,898.6 сая төгрөгийн өр төлбөр, авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын цахим системийн өр төлбөр, авлагын зөрүүг арилгаж, үнэн зөв тайлагнах.

2. Бараа материалын тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Жолоочийн шатахууны тооцоогоор үлдэгдэлтэй байгаа 0.1 сая төгрөгийн шатахууныг зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн зарцуулаагүй шатахууны үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тооцоог бодож баталгаажуулах.

3. Урьдчилж гарсан зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Тайлант онд визийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, зогсоолын төлбөр, хортон шавж устгалын зардалд 29.4 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар

болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын баталсан төсвийг зохистой удирдаж, өр төлбөр, авлага үүсгэхгүй байх.

4. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 4. Монгол Улсаас БНХАУ-ын Хөх хотод суугаа Дипломат төлөөлөгчид олгосон санхүүжилтийн зарцуулаагүй 356.2 юан буюу 0.2 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдлийг Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсаас БНХАУ-ын Хөх хотод суугаа Дипломат төлөөлөгчтэй тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулан, нягтлан бодох бүртгэлд тусгах.

5. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 5. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ-аас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 416.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй өгснийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.6-д "Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын "хүлээн зөвшөөрөлтийн зарчим" хангагдсан, үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ", 5.1-т "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгө шилжүүлэх талаар шийдвэр гаргуулж, хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэх.

6. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 6. Гадаадын иргэн, харьяатын газар шилэн дансны нэгдсэн цахим системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2.2 сая төгрөгийн 1 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг давтан гаргахгүй, Шилэн дансны тухай хууль, журмыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

7. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 667 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 112.6 сая төгрөгийн үнэлгээ бүхий 5,000.0 м2 газар эзэмших эрхийг шилжүүлэн авч бүртгэсэн боловч тус газрын кадастрын зургийг гаргуулаагүй, эзэмших эрхийн гэрчилгээг аваагүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-т "газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх", 27 дугаар зүйлийн 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно", 27.4-т "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно", 47 дугаар зүйлийн 47.1-д "Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын кадастрын зургийг гаргуулан, газар эзэмших эрхийн гэрчилгээг авч, нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнахыг зөвлөж байна.

ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газарт:

1. Бараа материалын тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 8. Жолоочийн шатахууны тооцоогоор үлдэгдэлтэй байгаа 0.1 сая төгрөгийн шатахууныг зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн зарцуулаагүй шатахууны үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд бүртгэн, тооцоог бодож, баталгаажуулах.

2. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 9. Тэмдэгтийн хураамжийн 2023 оны сүүлийн хагас жилийн тайланг илгээгээгүй, татварын цахим системийн тодорхойлолтоор 706.1 сая төгрөгийн илүү төлөлттэй байна.

Энэ нь Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-т "Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд гаргаж өгнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тэмдэгтийн хураамжийн тайланг нөхөн гаргаж, татварын цахим системийн авлагын зөрүүг арилгаж, тайлагнах.

3. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын суутгалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 10. Ажилтанд олгосон 0.5 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна", 19.1.3-т "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгохдоо хуульд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутган тайлагнаж байх.

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 11. ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар нь 1.4 сая төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг давтан гаргахгүй, Шилэн дансны тухай хууль, журмыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагчид:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 12. Гадаадын иргэн, харьяатын газрын харьяа нэгж газруудын санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгсэл 125.6 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 869.5 сая төгрөг, тавилга эд хогшил 40.0 сая төгрөг, программ хангамж 183.3 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 0.2 сая төгрөгийн нийт 1,218.8 сая төгрөгийн үнэ бүхий 366 нэр төрлийн 1032 ширхэг хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах, дахин үнэлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 13. Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 77.4 сая төгрөгийн 39 нэр төрлийн 76 ширхэг үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр харьяа байгууллагуудад шилжүүлсэн.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1-т “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй хөрөнгө шилжүүлсэн зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

Аудитаар нийт 6,169.9 сая төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 6,169.9 сая төгрөгийн 9 алдааг залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ГИХГ /аппарат/	5	6,158,304.4	1	4,447,483.1	4	1,710,821.3	5	6,158,304.4				
ГИХГ-ын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	3,000.0			1	3,000.0	1	3,000.0				
ГИХГ-ын Баруун бүс дэх газар	2	7,392.6	1	720.0	1	6,672.6	2	7,392.6				
ГИХГ-ын Хойд бүс дэх газар	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0				
Дүн	9	6,169,897.0	2	4,448,203.1	7	1,721,693.9	9	6,169,897.0				

Аудитаар нийт 117.5 сая төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 3.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 6.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 107.7 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
ГИХГ төвлөрүүлэн	2	77,380.6					2	77,380.6		
ГИХГ /аппарат/	7	31,996.1	2	2,324.8			5	29,671.3		

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ГАДААДЫН ИРГЭН ХАРЬАТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	4	1,427.1	1	737.4			3	689.7		
ГИХГ-ын Баруун бүс дэх газар	1	-					1	-		
ГИХГ-ын Хойд бүс дэх газар	5	6,689.5			2	6,689.5	3	-		
Дүн	19	117,493.3	3	3,062.2	2	6,689.5	14	107,741.6		

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 29.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 25.9 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 3.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ГИХГ /аппарат/	1	2,200.0					1	2,200.0
ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	1	1,424.2					1	1,424.2
Дүн	2	3,624.2					2	3,624.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ГИХГ /аппарат/	1	-					1	-
ГИХГ-ын Зүүн бүс дэх газар	1	25,874.5			1	25,874.5		
Дүн	2	25,874.5			1	25,874.5	1	-
Нийт дүн	4	29,498.7			1	25,874.5	3	3,624.2